

## “Хутагт Билгийн Цаад Чинадад Хүрэхүйн Зүрхэн”-ий тайлбар

*Энэтхэгийн хэлээр: Арья базар бара мида хридаяа жаа чаа*

*Төвөдийн хэлээр: Пагба шэйравжи паролдү чинби нинбу е намбар шадба*

*Монголын хэлээр: Хутагт Билгийн Цаад Чинадад Хүрэхүйн Зүрхэний тайлбар – Ялж Төгс Нөгцсөн Эх Билгийн цаад чинадад хүрэхүй дор мөргөмүй.*

“Ялж Төгс Нөгцсөн Эх Билгийн Цаад Чинадад Хүрэхүйн Зүрхэн” гэсэн нь уг судрын тодорхойлж буй. Тиймээс “Ялж Төгс Нөгцсөн Эх Билгийн Цаад Чинадад Хүрэхүйн Зүрхэн” гэжээ. Нэрийг эс дурдваас ямар судар болохыг үл таних тул юуны түрүүнд нэрийг нь дурдсан байна. Энэ төдийгөөр зогсохгүй “Билгийн цаад чинадад хүрэхүй”-н судар бүгд энд хураагдсан тул үүнийг “Судрын ч судар” гэж нэрлэдэг.

Үүнд, “Ялж” гэсэн нь дөрвөн дүдийг ялсны учир юм. Цогцсын дүд тэргүүтнийг Билгийн цаад чинадад хүрэхүйн утгаар хайвал “үл олдох” ба дүд бүгд “үл орших” тул “Ялж” гэсэн байна. “Төгс” хэмээсэн нь “зургаан сайн” төгөлдөр буюу таалалын эрдэм бүгд Билгийн цаад чинадад хүрэхүйн адистидээс бий болдог учир “Төгс төгөлдөр” гэжээ. “Эх” хэмээсэн нь гурван цагийн бурхан бүгд Билгийн цаад чинадад хүрэхүйд суралцсанаас бий болдог ба Билгийн цаад чинадад хүрэхүйн утгаар “төрдөг” билээ. Тиймээс Билгийн цаад чинадад хүрэхүй нь бурхан бүгдийн эх болох тул “Эх” гэсэн байна. “Билгийн” гэсэн нь сонсох, санах, дадуулахуйн гурван билгүүнээр чин үнэн ямар буйг түүнчлэн мэдэх тул ийн нэрлэжээ. “Цаад чинадад хүрэхүй” нь, билгүүнээр аливаа юмс бүгдийг “үл харах” тул тэмдэг хийгээд хоёр туйлшрал, төрөх, үхэх зэргээс гэтэлнэ. Иймийн тул “Цаад чинадад хүрэхүй” гэсэн байна. “Зүрхэн” хэмээсэн нь “Билгийн цаад чинадад хүрэхүй – Бум” судар тэргүүтний гүнзгий утга бүгд товч судар үүнд багтаагүй нь үгүй тул ийнхүү нэрлэжээ.

“Ялж Төгс Нөгцсөн Эх Билгийн цаад чинадад хүрэхүй дор мөргөмүй” гэсэн нь, “Билгийн цаад чинадад хүрэхүй – Бум” сударт “Билгийн цаад чинадад хүрэхүй дор мөргөх аваас гурван цагийн бурхан бүгдэд мөргөхтэй адил буй” хэмээн айлдсан тул буяны чуулганыг хураахын тулд, мөн тахихын тулд ийн мөргөл үйлдсэн байна.

### **Гол номлол**

Энэхүү “Билгийн цаад чинадад хүрэхүй”-г эхнээс төгсгөл хүртэл долоон хэсгээр тодорхой тайлбарлана. Долоон хэсэг нь,

1. удиртгал
2. билгүүнд орох

3. хоосон чанарын тодорхойлолт

4. билгүүний орон

5. билгүүний эрдэм

6. билгүүний үр дүн

7. билгүүний тогтоол юм. Эдгээрээс удиртгал нь “*Би бээр ийн хэмээн сонссон...*” гэдгээс “*...нэгэн дор суун авай.*” гэдгийг хүртэл,

Билгүүнд орох нь “*Таван цогцсыг ч мөн чанараар хоосон хэмээн харахтун*” гэдгийг хүртэл,

Хоосон чанарын тодорхойлолт нь “*Олох бус, олохгүй ч бус болой.*” гэдгийг хүртэл,

Билгүүний орон нь “*Олох үгүйгээр билгийн цаад чинадад хүрэхүйд оршиж, явахтун.*” хэмээхийг хүртэл,

Билгүүний эрдэм нь “*Гаслангаас гэтэлсний эцэст хүрэх болой.*” хэмээхийг хүртэл,

Билгүүний үр дүн нь “*Бодь дор илтэд төгсгөсөн бурхан болмуй*” хэмээхийг хүртэл,

Билгүүний тогтоол нь төгсгөлийн тарнийг хүртэл тус тус гарна.

## **1. Удиртгал**

“*Би бээр ийн хэмээн сонссон нэгэн цагт Ялж Төгс Нөгцсөн – Бурхан Багш Ражгирийн Тас Цогцолсон уулнаа гэлэн хуврагийн их аймаг хийгээд бодьсадвын их хуврагуудын хамт нэгэн дор залран авай.*” гэжээ. Их хөлгөний судрын аймгийн сургаал бүгдийг хутагт Манзушри бээр сонссон учир “*Би бээр сонссон*” гэж буй. Үүнээс “*ийн хэмээн*” гэсэн нь “Билгүүний Зүрхэн” судрыг хэлж байна. “*сонссон*” гэдэг нь Бурхан Багшийн дэргэд сонссон буюу түүний аман гэгээнээс шууд чихээр сонссоныг хэлж буй. “*нэгэн цагт*” гэсэн нь “Билгүүний Зүрхэн” судрыг бусад цаг үед номлоогүй буюу Бурхан Багш Ражгирт эдгээр шавь нарт ганцхан удаа номлосныг илэрхийлж буй. “*Ялж Төгс Нөгцсөн – Бурхан Багш*” гэдэгт номлох багшийг хэлж байна. Эдгээрээр багш нь хэн, аль нутагт, ямар ямар шавь нарт, тэдэнд ямар утга номлосон гэдгийг үзүүлжээ. Багш нь Ялж төгс Нөгцсөн – Бурхан Багш, газар нутаг нь Ражгирийн Тас Цогцолсон уул, нөхөд шавь нь олон гэлэн, бодьсадва хийгээд их бодьсадва нар бөгөөд эдгээр шавь нарт ямар утгыг айлдсан буй хэмээвээс “Билгийн цаад чинадад хүрэхүй – Билгүүний Зүрхэн” үүнийг номложээ.

“*Ражгирийн*” гэсэн нь Бимбисара хааны нөлөөгөөр олонд алдаршсан тухайн нутгийн нэр юм. “*Тас Цогцолсон уул*” гэдэг нь оройд нь олон шувууд оршдог уулын

нэр, “гэлэн хуврагийн их аймаг” гэсэн нь олон хувраг цугласныг илэрхийлж байна. “бодьсадвын их хуврагууд” гэсэн нь бүгд билгийн цаад чинадад хүрэхүйн бүрэн утгыг илтэд болгоосон, мөн үүгээр билгийн цаад чинадад хүрэхүйд оршсон олон бодьсадва тэнд байсныг илэрхийлж байна. “нэгэн дор залран авай.” гэсэн нь Бурхан Багшийг олон нөхөд тойрон хүрээлж суусныг харуулжээ.

Энэ хүртэл удиртгал хэсэг болно.

## **2. Билгүүнд орохуй**

Одоо билгүүнд орохуй хэсгийг тайлбарлая. “Тэр цагт Ялж Төгс Нөгцсөн – Бурхан Багш “юмсын гүн үзэгдэл” хэмээх самадид тэгш оршив.” гэжээ. Бурхан Багш тэнд буй шавь нөхдийг, мөн хамаг амьтдыг энэрэн таалж, адислахын тулд тэгш оршихуйн бясалгалд суусан байна.

Энэхүү самадийг “юмсын гүн үзэгдэл” гэж нэрлэсэн нь энэ номоор юмс бүгдийг зоригдол хийгээд туйлшрал бүгдээс гэтэлдэг гэдгийг үзүүлж, үүнийг ойлгуулахын тулд “юмсын гүн үзэгдэл” гэсэн байна.

“самадид тэгш оршив.” гэсэн нь тэрхүү гүн самадид оршихыг хэлж байна.

“Ахин тэр цагт, бодь сэтгэлт махасадва, хутагт Жанрайсиг бээр Билгийн цаад чинадад хүрэхүйн гүн явдал үүнийг тунгаан бодоод таван цогцсыг ч мөн чанараар хоосон хэмээн харав.” гэжээ. Үүнээс “Ахин тэр цагт” гэдэг нь олон нөхдийн хамт тэгш оршиж буй тухайн цаг үеийг хэлж байна. “Хутагт Жанрайсиг” гэдгээс “мөн чанараар хоосон хэмээн харав” гэдэгт хутагт Жанрайсиг тэдгээр нөхдийн хамт хамаг амьтдыг энэрэн таалж, Билгийн цаад чинадад хүрэхүйг тунгаан бодож таван цогцос нь ч тусагдахуун үгүй чанартай, хоосон чанараас өөр чанарт нэгээхэн ч урвахгүй гэдгийг таалан болгоосныг илэрхийлж байна.

“Таван цогцос”-ын дүрст цогц нь хоосон хөндий, мэдрэхүйн цогц нь усны хөөс, мэдэхүйн цогц нь зэрэглээ, үйлдэхүйн цогц нь зэгс, ухамсарын цогц нь илбийн үзэгдэл адил билээ. “мөн чанараар хоосон” гэдэг нь эдгээр таван цогцос туйлшрал бүгдээс гэтэлсэн, мөн чанар үгүй тул хоосон чанартай гэсэн утгыг илэрхийлж байна.

“Ингээд насан төгөлдөр Шарипутра (Шаарийбү) Бурхан Багшийн адистидын хүчээр бодь сэтгэлт махасадва, хутагт Жанрайсигт ийн өгүүлвэй.” гэсэн нь их ширвага нарын дотроос хамгийн дээд билгүүн төгөлдөр Шарипутра Бурхан Багшийн адистидын хүчээр хутагт Жанрайсигээс ийнхүү асуув гэсэн утгатай юм.

“Язгуурын хөвгүүн хэн нэгэн Билгийн цаад чинадад хүрэхүйн гүн явдлаар явахыг хүсэгч бээр хэрхэн суралцах болой” гэсэн байна. “Язгуурын хөвгүүн” гэдэг нь их хөлгөний эрхэм зарлигаас төрж, Бурханы хөвгүүн болсон учир ийн нэрлэсэн буй. “хэн нэгэн” гэсэн нь их хөлгөнд орсон хүн бүхнийг хэлж буй. “Билгийн цаад чинадад хүрэхүйн явдлаар” гэсэн нь, билгийн цаад чинадад хүрэхүйг дадлага болгосноор юмс бүгдийн гүн мөн чанарыг өгүүлшгүйгээр болгоодог. “Үүнийг хүсэгчид хэрхэн суралцах болой” гэсэн нь билгийн цаад чинадад хүрэхүйн утгыг ухаарахыг хүсэгчид юуг мэдэж, түүнд хэрхэн суралцах вэ гэсэн асуулт юм.

“Ийн өгүүлэхүйд бодь сэтгэлт махасадва, хутагт Жанрайсиг насан төгөлдөр Шарипутрад ийн хариулвай.” гэсэн нь Шарипутрагийн асуултанд хутагт Жанрайсиг хариулсныг илэрхийлж байна.

“Шарипутра! Язгуурын хөвгүүн хийгээд язгуурын охин хэн нь ч билгийн цаад чинадад хүрэхүйн гүн явдлаар явахыг хүсэгчид үүнчлэн шинжихтүн” гэсэн нь Билгийн цаад чинадад хүрэхүйд суралцахыг хүсэгчид хойно номлох утгыг ажиглан шинжихтүн гэсэн утгатай.

“Таван цогцос эдгээр нь ч мөн чанараар хоосон хэмээн чин үнэнээр сайтар харахтун” гэдгээр таван цогцос мөн чанартаа хоосон гэдгийг харуулж байна. Мөн чанар үгүй тул урьд өмнө төрөөгүй, өдгөө үл орших ба ирээдүйд ч эвдэрч үгүй болно гэж байхгүй тул цаг үргэлж тэдэнд төрөх, орших, эвдрэх чанар гэж байхгүй. Иймээс үл оршихуйн өгүүлшгүй мөн чанартай тул хоосон чанартай билээ. “харахтун” гэсэн нь чин үнэнээр нь харахтун, үүнээс өөрөөр бүү хар гэсэн утгатай.

Энэ хүртэл билгүүнд орох хэсэг юм.

### **3. Хоосон чанарын тодорхойлолт**

Одоо хоосон чанарын тодорхойлолтыг тайлбарлая. Үүнд “Дүрс хоосон, хоосон нь ч дүрс болой.” хэмээн айлдсан байна. “Дүрс” гэдэг нь, хоосон чанарын мөн чанарыг үл ухаарсны учир эндүүрсэн сэтгэлээр дүрс хэмээн харж, төсөөлсөн ба мөн үүнийг үгээр томьёолсон төдий гэсэн утгатай. “хоосон болой.” гэсэн нь, дүрсийн мөн чанар хоосон учир өнгөрсөн цагт бэлгэ чанар үгүйн улмаас тусагдахуун үгүй, одоо хийгээд ирээдүйд ч бэлгэ чанар үгүй буюу тусагдахуун үгүй билээ. Ийнхүү хязгаар бүгд, юмс бүгд үл орших учир “хоосон болой” гэжээ.

“Хоосон нь ч дүрс болой.” гэсэн нь, тусагдахуун үгүй мөн чанарыг дүрс хэмээн үгээр томьёолсон бөгөөд энэ нь үгүй болох аваас үл орших тул хоосон чанар нь ч дүрс юм.

“Дүрсээс тусад хоосон чанар үгүй, хоосон чанараас ч тусад дүрс үгүй.” гэсэн нь, дүрс бээр өгүүлшгүй хоосон чанартай тул дүрсээс тусдаа хоосон чанарыг эрж хайгаад үл

олдоно. Иймээс дүрсээс тусдаа хоосон чанар гэж байхгүй. Өгүүлшгүй хоосон чанарыг дүрс хэмээн үгээр томъёолсныг үгүй болговол олдох зүйлгүй болно. Тиймээс хоосон чанараас ч тусдаа дүрс үгүй гэжээ.

“*Үүнчлэн мэдрэхүй, мэдэхүй, үйлдэхүй, ухамсар бүгд хоосон болой.*” гэсэн нь, дүрсийг хэрхэн номлосонтой адил бусад цогцос ч түүнтэй адил гэдгийг айлдсан байна.

“*Шарипутра! Энэ мэт юмс бүгд хоосон чанартай буюу...*” гэдгийн “*Шарипутра!*” гэдэгт сэтгэл төвлөрч, анхаарал хандуулж, сайтар сонсохыг хүсч түүнийг дууджээ. “*Энэ мэт юмс бүхэн хоосон чанартай буюу*” гэдэг нь таван цогцсыг хэрхэн тайлбарласантай адил зургаан төрөн түгэхүйгээс эхлэн Бүхнийг Болгоогч (бурханы таалал) хүртэлх юмс бүгд ч хоосон чанартай гэдгийг мэдэхтүн гэсэн утгатай.

“*Бэлгэ чанар үгүй*” гэдэг нь огторгуйд бэлгэ чанар үгүйн адил нисваанисын бэлгэ чанар байхгүй, түүнийг арилгасан эрдмийн бэлгэ чанар ч байхгүй билээ.

“*Төрөх үгүй, хаагдах үгүй*” гэсэн нь, урьд өмнө байгаагүй зүйл хожим шинээр бий болохыг “төрөх” гэх ба “хаагдах” гэдэг нь урьд байсан зүйл хожим хаагдаж үгүй болохыг хэлнэ. Хоосон чанар нь тусагдахуун үгүй тул урьдаас төрөөгүй, төрөөгүй тул хаагдаж үгүй болно гэж байхгүй билээ.

“*Хир үгүй ба хирээс хагацах нь ч үгүй*” гэсэн нь, хирийг ухамсар тодорхойлдог. Хоосон чанар нь ухамсараас хэтэрсэн тул “*хир үгүй*” юм. “*хирээс хагацах нь ч үгүй*” гэдэг нь хиргүй тул хирээс хагацана гэж байхгүй гэсэн утгатай.

“*Хомсдох нь үгүй, дүүрэх нь ч үгүй.*” гэдгийн “*хомсдох*” нь амьтдыг хэлэх ба “*дүүрэх*” гэдгээр бурханыг хэлж буй. “*үгүй*” гэсэн нь амьтан хийгээд бурханыг хайгаад үл олдох тул хомсдох, дүүрэх нь үгүй гэжээ.

(Таван цогцос бус)

“*Шарипутра! Ийн үзвээс хоосон чанар нь дүрс бус,*” гэдэг нь, дүрс эвдэрч үгүй болдог чанартай, хоосон чанарт ийм чанар үгүй тул дүрс бус гэсэн утгатай. Мэдрэхүй нь мэдрэх чанартай, хоосон чанарт энэ нь үгүй тул “*мэдрэхүй бус*”, мэдэл нь таниж мэдэх чанартай, хоосон чанарт энэ үгүй тул “*мэдэхүй*” бус, үйлдэл нь илтэд үйлдэх чанартай тул “*үйлдэхүй*” ч бус, ухамсар нь юмсыг тус бүрчилэн таних чанартай, гэтэл хоосон чанарт тусагдахуун үгүй тул “*ухамсар*” бус билээ. “*эдгээр бус*” гэсэн нь таван цогцос цувиралт чанартай, тиймээс хоосон чанар нь эдгээр таван цогцос бус гэсэн утгатай.

(Эрхтэн бус)

“Нүд бус” гэдэг нь нүд харах чанартай, харин хоосон чанарт ийм чанар үгүй тул нүд бус, “чих бус” чих нь сонсох чанартай тул чих бус, “хамар бус” хамар үнэрлэх чанартай тул хамар бус, “хэл бус” хэл нь амтыг амсах чанартай, хоосон чанарт энэ нь үгүй тул хэл бус, “бие бус” бие нь хүрэлцэх чанартай, хоосон чанарт энэ нь үгүй тул бие бус, “сэтгэл бус” сэтгэл нь юмсын хувь чанарыг тодорхойлдог чанартай, хоосон чанарт энэ нь үгүй тул сэтгэл бус билээ. Эдгээр зургаан эрхтэн нь тусагдахуун юмсыг барих чанартай, харин хоосон чанарт энэ үгүй тул зургаан эрхтэн бус юм.

(Тусагдахуун орон бус)

“Дүрс бус” дүрс нь өнгө хийгээд хэлбэрийн чанартай, хоосон чанарт энэ үгүй тул дүрс бус, “дуу бус” дуу нь яруу хийгээд яруу бус чанартай, хоосон чанарт энэ үгүй тул дуу бус, “үнэр бус” үнэр нь үнэртэх чанартай тул хоосон чанар үнэр бус, “амт бус” амт нь амтлах чанартай тул хоосон чанар амт бус, “хүрэлцэхүй бус” хүрэлцэх нь хатуу, ширүүнийг мэдрэх чанартай тул хоосон чанар хүрэлцэхүй бус, “юмс бус” юмс нь хувь бүрийн чанартай, хоосон чанарт энэ нь үгүй тул юмс бус билээ. Үүнчлэн үзвээс тусагдахуун орон (объект) нь түүнд зорьж чиглэсний улмаас тодорхойлогддог, харин хоосон чанарт ийм чанар үгүй тул орон бус юм.

“Нүдний орон бусаас сэтгэлийн орон бус, сэтгэлийн ухамсарын орныг хүртэл бус болой.” гэсэн байна. Эдгээр арван найман орон нь гуа бус чанартай, хоосон чанарт энэ нь үгүй тул арван найман махбодь бус билээ.

(Арван хоёр шүтэн барилдлага бус)

“Мунхаг”-аас “өтлөх, үхэх”-ийг хүртэл бус, “мунхаг барагдахаас”-аас “өтлөх, үхэх барагдах” хүртэл ч бус” гэдэгт “мунхаг”-аас “өтлөх, үхэх” хүртэлх арван хоёр шүтэн барилдлага нь орчлонд хүлэх чанартай, гэтэл хоосон чанарт ийм чанар үгүй тул “мунхаг”-аас “өтлөх, үхэх” хүртэлх арван хоёр шүтэн барилдлага бус юм. “Мунхаг барагдах”-аас эхлэн “өтлөх, үхэх барагдах” хүртэл бүгд машинд арилган ариусгах чанартай, хоосон чанарт энэ нь мөн үгүй тул мунхаг барагдахаас өтлөх, үхэх барагдах хүртэлх бүгд бус гэжээ.

(Дөрвөн үнэн бус)

Дараа нь “Зовлон, бүхэн гарахуй, хорихуй, мөр бус болой.” гэж айлдсан байна. Зовлон нь нисваанисын чанартай, бүхэн гарахуй нь уг болох чанартай, хорихуй нь амирлуулах чанартай, мөр нь мэдэхүйн чанартай бөгөөд хоосон чанарт эдгээр чанар үгүй тул дөрвөн үнэн бус юм.

“Билиг билгүүн бус” билиг билгүүн нь юмс бүгдийг илтэд болгоох чанартай, хоосон чанарт энэ чанар үгүй тул билиг билгүүн бус, “олох бус, олохгүй ч бус” гэдгийн олох нь ханьцашгүй, үнэнхүү төгсгөсөн бурханы хутагийг хэлнэ. Эс олох гэдэг нь амьтад тэрхүү бурханы хутагийг олж чадаагүйг хэлж буй. “Олох бус, олохгүй ч бус” гэдгийн “бус” нь хоосон чанарт ханьцашгүй дээд бурханы хутаг гэж үгүй, амьтан ч гэж үгүй тул олох гэж үгүй, олохгүй ч гэж үгүй болохыг илэрхийлж байна. Ийнхүү үзвэл “юмс бүгд мөн чанартаа хоосон ба хоосон чанар нь энэ мэт болой” гэдгийг энэ хэсэгт харуулжээ.

Билгүүний тодорхойлолтыг тайлбарлав.

#### **4. Билгүүний орон**

Одоо билгүүний орон гэж юу болохыг тайлбарлая. “Шарипутра! Энэ мэт бодьсадва олох үгүйгээр билгийн цаад чинадад хүрэхүйд оршиж, явахтун” гэсэн байна. Эс мэдсэнээ мэдэв хэмээх сэтгэл төрүүлэхийн тулд билгийн цаад чинадад хүрэхүйн энэ төдий явдлаар хоосон чанарт орж буй гэдгийг энд гаргажээ. “Энэ мэт” гэсэн нь, ийнхүү юмс бүгд хоосон чанартай болой гэдгийг илэрхийлж байна. “Бодьсадва нар олох үгүйгээр билгийн цаад чинадад хүрэхүйд явахтун” гэсэн нь, их хөлгөнд оршсон бодьсадва нар таван цогцсоос эхлэн Бүхнийг Болгоогч – Бурханы таалал хүртэлх юмс бүгдийн алин нь ч олдохгүй гэдгийг ухаарч, юмс бүгдийг хумхын тоосны төдийд ч харалгүй билгийн цаад чинадад хүрэхүйд суралцахтун гэсэн утгатай.

Үзэгдэл юмс бүгд хоосон чанартай буюу үл оршихуйн чанартай боловч үүнийг үл ухаарсан, мунхагийн эндүүрсэн сэтгэлд баригдвал орчлонгийн далайд эргэлдэж, тэнэх болно. Тэрхүү эндүүрсэн сэтгэлийг гурван билгүүнээр шинжин нягталваас сэтгэл нь зоригдол үгүй тул нисваанисыг харахгүй, түүнийг арилгасан асар ариуныг ч олж харахгүй ба таван цогцсоос эхлэн Бүхнийг Болгоогч – Бурханы таалал хүртэлх бүгдийг харахгүй. Хоосон чанар, бэлгэ чанар үгүй, үл төрөх, үл хорихуй зэргийг харахгүй. Билгүүнийг чин үнэнээр харахгүй.

Юуг ч үл харснаар сэтгэлийн мөн чанарыг харна. Сэтгэлийн мөн чанарыг харснаар бодийн хутагийг харна. Бодийн хутагийг харсан нь мөн чанараар бурханыг харна. Мөн чанараар бурханыг харагч бээр ханьцашгүй бодийн хутаг дор бурханы хутагийг олж гэгээрэх болой гэсэн утгатай.

#### **Энэ хэсэгт эргэлзээг арилгах нь,**

Асуулт: Ийнхүү үргэлж юу ч үгүйг номлох тул тэрсүүд нар юмсыг үгүйсгэх ба ширвага нар амирлангуйн хязгаарт унах уу?

Хариулт: Тийм бус. Учир нь үл зорихуйн ёсоор амьтны тусыг бүтээж, түүнийгээ ханьцашгүй дээд бурханы хутаг олохын төлөө зориулах ба зургаан барамид тэргүүтнийг үл зорих ёсоор үйлдэх тул ийм алдаа гарахгүй билээ.

Энэ хүртэл билгүүний орныг тайлбарлав.

## **5. Билгүүний эрдэм**

Одоо билгүүний эрдмийг тайлбарлая. *“Сэтгэлд айдас үгүй тул түйтгэр үгүй ба чанх буруугаас машид гэтэлж, гаслангаас гэтэлсний эцэст хүрэх болой.”* гэж айлдсан байна. Билгийн цаад чинадад хүрэхүйн утга хоосон чанарын тухай сонсож, санаж, бясалгаснаар айдас үл төрөх тул сэтгэл, ухамсар, авьяас бүгдийг буцааснаар сэтгэлийн түйтгэр үгүй болно. Нялхас мэт явдалтай тэрсүүд нар, мөн ширвага, брадигабудда нарын явдлаас машид хэтэрснээр нисваанисын түйтгэр хийгээд мэдэгдэхүүний түйтгэр бүгдийг барж, гаслангаас гэтэлсэн их хутагт хүрэх болно.

Энэ хүртэл билгүүний эрдмийг өгүүлэв.

## **6. Билгүүний үр**

Одоо билгүүний үрийг тайлбарлая. *“Гурван цагт машид ажирсан бурхан бүгд ч билгийн цаад чинадад хүрэхүйд оришин ханьцашгүй дээд, үнэнхүү төгсгөсөн бурханы хутаг дор бурхан болмуй.”* гэжээ. Арван зүгийн ертөнцийн оронд, гурван цагт ажирсан бурхан бүгд Билгийн цаад чинадад хүрэхүй үүнийг тогтоож, уншиж, амны уншлага болгож, бясалгаж, бусдад зааж, билгийн цаад чинадад хүрэхүйд суралцсанаар ханьцашгүй дээд бурханы хутагт хүрчээ. Гурван цагийн бурхан бүгд билгийн цаад чинадад хүрэхүйгээс төрсөн, түүнээс гарсан тул Билгийн цаад чинадад хүрэхүй нь бурхан бүгдийн эх болдог.

Энэ хүртэл билгүүний үрийг номлов.

## **7. Билгүүний тогтоол**

Одоо билгүүний тогтоол тарнийг тайлбарлая. *“Иймийн тул Билгийн цаад чинадад хүрэхүйн тарни нь үнэн бөгөөд үл эндүүрсэн болой.”* гэж айлдсан байна. *“Иймийн тул”* гэсэн нь өмнө айлдсан бүгдийг дурдаж байна. *“билгийн цаад чинадад хүрэхүйн тогтоол тарни нь үнэн бөгөөд үл эндүүрсэн болой.”* гэсэн нь билгийн цаад чинадад хүрэхүйн утгыг ухааруулах тул тарни гэжээ. Ертөнцийн юмс бүгдийг ханьцашгүй бодийн их хөлгөн болгож, би болон бусад хамаг амьтдыг ханьцашгүй дээд бодийн хутаг дор бурхан болгох тул *“үнэн бөгөөд үл эндүүрсэн”* гэжээ.



“Их ухааны тарни” гэсэн нь, Билгийн цаад чиндад хүрэхүйн утгыг ухааруулагч тарни нь хүсэл тачаал, уур хилэн, мунхаг ба орчлонгийн зовлон бүгдийг өгүүлшгүй мөн чанартайд үзүүлдэг тул Билгийн цаад чинадад хүрэхүй нь их ухааны тарни болдог гэсэн утгатай.

“Ханьцашигүй дээд тарни” гэсэн нь, Билгийн цаад чинадад хүрэхүй нь ханьцашигүй дээд хутагийг бий болгодог тул ийн нэрлэжээ.

“Үл тэнцэхүй хийгээд тэнцүүлэгч тарни” гэсэн нь, Билгийн цаад чинадад хүрэхүйг ертөнцийн эгэл хүмүүс, мөн ширвага, брадигабудда нарын явдалтай тэнцүүлэшгүй ба бурхан бүгдийн билиг билгүүнтэй адил тэгш болгох тул “үл тэнцэхүй хийгээд тэнцүүлэгч тарни” юм.

“Зовлон бүгдийг машид амирлуулагч тарни гэж мэдэхтүн” гэсэн нь, Билгийн цаад чинадад хүрэхүйн номыг барих, унших, амны уншлага болгох, ёсчилон бодох, бусдад номлосноор нүдний өвчин тэргүүтэй өвчин бүгд үгүй болох ба арван зүгийн бурхад, тэнгэр, лус зэргүүд ч аварна, Билгийн цаад чинадад хүрэхүйн явдлаар явбал муу заяа, орчлонгийн далайг үгүй хийх тул “зовлон бүгдийг машид амирлуулагч тарни” гэжээ.

“Билгийн цаад чинадад хүрэхүйн тарнийг өгүүлэхүй – Датяата гадэ гадэ бара гадэ барасам гадэ боди сууха”

Билгийн цаад чинадад хүрэхүйн энэ тарни дээд гүнзгий утга бүгдийг хураасан тул “адисласан тарни” хэмээн айлдсан буй.

“Шарипутра! Бодь сэтгэлт махасадва нар энэ мэт Билгийн цаад чинадад хүрэхүй гүн үүнд суралцахтун!” гэсэн нь, гурван цагийн бурхан бүгд Билгийн цаад чинадад хүрэхүйн явдлаар явсны үр дүнд бурханы хутагийг олсон тул их хөлгөнд орсон бодьсадва нар Билгийн цаад чинадад хүрэхүйд суралцахтун гэсэн утгатай.

“Ингээд Ялж Төгс Нөгцсөн – Бурхан Багш самадийн бясалгалаас босоод...” гэсэн нь, Бурхан Багш гүн самадийн бясалгалд суусны хүчээр Шарипутра асуулт асуусан ба хутагт Жанрайсиг тайлбарлан хариулж дууссаны дараа бясалгалаас боссон байна.

“Бодь сэтгэлт махасадва, хутагт Жанрайсигт “Сайн болой” хэмээгээд” гэжээ. “Сайн болой” хэмээн магтсан нь Билгийн цаад чинадад хүрэхүйн утгыг тайлбарласан нь бурхан бүгдийн айлдсантай адил бөгөөд үл эндүүрсэн тул ийн магтсан байна.

“Язгуурын хөвгүүн! Тэр түүнчлэн болой. Язгуурын хөвгүүн! Тэр түүнчлэн буюу чиний хэрхэн номлосны дагуу Билгийн цаад чинадад хүрэхүйд суралцахтун” гэжээ. Хутагт

Жанрайсиг хэрхэн өгүүлсэн нь бурхан бүгдийн айлдвартай нийцсэн тул “түүнчлэн болой” гэжээ. Хутагт Жанрайсиг Билгийн цаад чинадад хүрэхүйг номлосны дагуу их хөлгөнд оршсон бодьсадва нар суралцахтун гэсэн утгатай.

*“Түүнчлэн Ажирсан – Бурхад ч даган баясмуй”* гэжээ. Хутагт Жанрайсигийн тайлбарт Түүнчлэн Ажирсан – Бурхад ч баясан байхад бусдын хувьд эргэлзэх юун гэсэн утгатай.

*“Ялж Төгс Нөгцсөн – Бурхан Багш баясалтайгаар ийн айлдаад...”* гэсэн нь, Билгийн цаад чинадад хүрэхүйг ийнхүү өгүүлснээр тэнд байсан олон нөхөд Билгийн цаад чинадад хүрэхүйн утгыг мэдэж, их хөлгөнд саад тотгоргүй болсон тул баясалтайгаар ийн айлдсан гэсэн утга юм.

*“Насан төгөлдөр Шарипутра, бодьсадва Жанрайсиг, тэнгэр, хүн, асури, гандирс сэлт нөхөр бүгд Ялж Төгс Нөгцсөн – Бурхан Багшийн айлдварт илтэд баясмуй”*

Ловон Зана Мидагийн зохиол “Ялж, Төгс Нөгцсөн, Эх Билгийн цаад чинадад хүрэхүйн зүрхэн”-ий тайлбар төгсөв.